

МОНГОЛБАНК

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2015 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр

1. Монголбанк нь АСН (Automated Clearing House) системийг нэвтрүүлэх зорилгоор гүйлгээний програмын зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн, хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцоог боловсруулах систем (АСН-Automated Clearing House) нэвтрүүлэх талаар судалгаа хийх, уг системийг худалдан авах олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын ажлын даалгавар (bidding documents)-ын төсөл боловсруулах ажлыг 45 хоногт багтаан гүйцэтгэх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээлэл (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт)-ийг ирүүлнэ. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно. Гадаадын этгээд оролцох эрхтэй.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 17.00 цагаас өмнө утсаар болон и-мэйлээр авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2015 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 11.00 цагаас өмнө өөрийн биеэр болон и-мэйлээр ирүүлнэ үү.

МОНГОЛБАНК

Мэдүүлэг хүлээн авах хаяг: Бага тойруу -3, 15160, Улаанбаатар хот,
Монголбанкны “А” байрны 1 давхар 2 тоот өрөө,

Харилцах албан тушаалтны нэр:
Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын Үндэсний цахим гүйлгээний төвийн
Ахлах мэргэжилтэн Л.Баттөгөлдөр
Утас: (976) 11-324986 , Факс: (976)-11-311471
и-мэйл хаяг: battuguldur@mongolbank.mn